- IV. Жижиг дунд үйлдвэрийг сумын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Цэнгэл сумын Засаг дарга нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Тайлант онд тус албанаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхтэй холбоотой Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна..

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,929.0 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	149.4	175.0	25.6
Авлага	296.2	409.7	113.5
Урьдчилж гарсан зардал			-
Бараа материал	4.5	5.7	1.2
Нөөцийн бараа	82.8	62.4	(20.3)
Үндсэн хөрөнгө	4,494.9	4,276.1	(218.8)
Нийт хөрөнгө	5,027.8	4,929.0	(98.8)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,027.8	4,929.0	(98.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5,027.8	4,929.0	(98.8)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Судалгаанаас мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Өр төлбөр данс өөрчлөлт гараагүй байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 175.0 сая төгрөг болж, өмнөх оноос 25.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	149.4	175.0	25.6
Төгрөг	149.4	175.0	25.6
Төрийн сангийн харилцах	149.4	175.0	25.6
Арилжааны банк дахь харилцах	0.0	-	(0.02)
Дүн	149.4	175.0	25.6

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Мөнгөн хөрөнгө данс оны эхний үлдэгдэлтэй 25.6 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын данс, ОНХС, ХХС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой, байна. Орон нутгийн ерөнхий орлогын данс 132.2 сая төгрөгийн, ОНХС-гийн данс 38.1 сая төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн данс 4.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, Эмийн эргэлтийн сангийн данс үлдэгдэлгүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 409.7 сая төгрөг болж, өмнөх оноос 113.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	20.7	32.1	11.4
Байгууллагаас авах авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-	-
Зээлийн авлага	275.5	377.7	102.2
Хувь хүмүүст олгосон зээл	275.5	377.7	102.2
Дүн	296.2	409.7	113.5

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 113.5 сая төгрөгөөр өссөн нь зээлийн хүүгийн авлага 11.4 сая, хувь хүмүүсээс авах авлага 102.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгосонтой холбоотой байна. Тайлант онд ХХС-гийн эргэн төлөлтөөс 195.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 5.7 сая төгрөг болж, өмнөх оноос 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	-	-	-
Эм боох материал	-	-	-
Хангамжийн материал	4.5	5.7	1.2
Бичиг хэргийн материал	-	-	-
Аж ахуйн материал	0.2	0.2	-
Түлш, шатах тослох материал	-	-	-
Бусад хангамжийн материал	4.3	5.5	1.2
Мал амьтад	-	-	-
Дүн	4.5	5.7	1.2

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Бараа материалын данс 1.2 сая төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ-ын бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Бараа материал данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Нөөцийн бараа оны эхний үлдэгдлээс 62.8 сая төгрөгийн тэжээл зарцуулж, 2.4 сая төгрөгийн тэжээл худалдан авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 40.0 сая төгрөгийн тэжээлийн нөөц бэлтгэж оны эцэст 62.4 сая төгрөгийн тэжээлийн нөөцийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгийн буюу Нөөцийн бараа үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	82.7	62.4	20.3
Тэжээлийн нөөц	82.7	62.4	20.3
Дүн	82.7	62.4	20.3

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 4,276.1 сая төгрөг болж, өмнөх оноос 218.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	4,333.3	4,113.1	(220.2)
Барилга, байгууламж, орон сууц	1,436.8	1,395.9	(40.9)
Авто-тээврийн хэрэгсэл	15.4	10.5	(5.0)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,638.3	1,514.9	(123.4)

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тавилга, аж ахуйн эд хогшил	17.3	16.5	(0.9)
Зам, гүүрийн байгууламж	1,044.5	1,004.3	(40.3)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	-	-
Бусад үндсэн хөрөнгө	180.9	171.1	(9.9)
Дуусаагүй барилга, байгууламж	-	-	-
Ном	-	-	-
Биет бус хөрөнгө	161.6	163.0	1.4
Программ хангамж	-	1.4	1.4
Бусад биет бус хөрөнгө	161.6	161.6	-
Дүн	4,494.9	4,276.1	(218.8)

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Үндсэн хөрөнгийн данс 218.8 сая төгрөгөөр буурсан нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдэж, акталсан хөрөнгө, тайлант оны элэгдлийн зардлаар буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- *ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.*

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөр данс оны эхэн, эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,929.0 сая төгрөг болж, тайлант оны үр дүнгийн хэмжээгээр -98.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	520.7	520.7	-
Хуримтлагдсан үр дүн	4,033.8	3,935.0	(98.8)
Өмнөх үеийн үр дүн	11,720.4	4,033.8	(7,686.6)
Тайлант үеийн үр дүн	(7,686.6)	(98.8)	7,587.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	473.3	473.3	-
Дүн	5,027.8	4,929.0	(98.8)

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэнгэл сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 2,531.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,706.9 сая төгрөгийг урсгал зардалд, 825.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 364.1 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 1,450.6 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогын санхүүжилтээр, 517.2 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас, 200.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Цэнгэл сум нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,924.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 364.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 943.9 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 517.2 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 99.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой 421.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 68.6 сая төгрөгийг төвлөрүүлж, үндсэн үйл ажиллагааны орлого /хоршоо хөгжүүлэх сан/ 101.0 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,984.3 сая төгрөг буюу 78.3 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн болон дутуу авсан санхүүжилт, тасарсан орлого, эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 99.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Цэнгэл сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 812.9 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 1.142.5 сая төгрөгөөр буюу 329.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар хуралдааны тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 1,142.5 сая төгрөгөөр хэвээр нь баталжээ.

Гүйцэтгэлээр сумын орон нутгийн төсвийн орлогод нийтдээ 1,044.8 сая төгрөгийн орлого оруулж, төлөвлөгөө 97.7 сая төгрөгөөр буюу 8.6 хувиар тасарсан байна. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 48.7 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

				<i>/сая төгрөг/</i>	
<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт /-/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>	
I.Татварын орлого	1130.3	999.4	-130.9	88.4	
II.Татварын бус орлого	12.2	45.4	33.2	372.1	
Нийт дүн	1142.5	1044.8	-97.7	91.4	

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Орон нутгийн орлого төлөвлөгөө тасрахад цалин хөлсний орлогоос 129.6 сая, үйл ажиллагааны орлогын албан татвар 72.7 сая, бууны албан татвар 0.3 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 36.2 сая, хог хаягдлын хураамж 12.2 сая, ойн нөөцийн төлбөр 83.5 сая төгрөгөөр тасарч, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогоос суутгасан албан татвар буюу хөрөнгийн орлого 143.9 сая, улсын тэмдэгтийн хураамж 0.7 сая,

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

газрын төлбөр 12.0 сая, хүү, торгуулийн орлого 15.2 сая төгрөгөөр давж, орлогын төлөвлөгөө өгөгдөөгүй малд ногдуулах албан татвараас 55.5 сая төгрөгийн, дуудлага худалдаа, бусад нэр заагдаагүй орлогоос 17.9 сая орлого оруулсан нь орон нутгийн орлого бүрдүүлэхэд голлон нөлөөлсөн байна. Хөрөнгө борлуулсны орлого, үл хөдлөх хөрөнгийн татвар 100 хувь тасарсан байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 149.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын дансаар 1,044.8 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 68.8 сая төгрөгийн санхүүжилтийн орлого төвлөрч, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 132.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/сая төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Сумын ИТХ	139.0	117.9	-21.1
2	Сумын ЗДТГ	795.9	626.3	-169.6
3	Ерөнхий боловсролын 1-р сургууль	195.9	195.9	0.001
4	Ерөнхий боловсролын 2-р сургууль	137.3	124.0	-13.3
5	Ерөнхий боловсролын 3-р сургууль	24.4	15.7	-8.7
6	Ерөнхий боловсролын 4-р сургууль	16.4	16.4	-
7	Хүүхдийн 1-р цэцэрлэг	25.2	25.2	0.0
8	Хүүхдийн 2-р цэцэрлэг	19.5	19.5	-
9	Хүүхдийн 3-р цэцэрлэг	17.4	17.3	0.0
10	Хүүхдийн 4-р цэцэрлэг	13.5	13.5	-
11	Соёлын төв	66.6	57.1	-9.5
12	Эрүүл мэндийн төв	55.9	55.3	0.6
13	ОНХСан	825.0	557.5	-267.5
14	СХС	200.0	99.0	-101.0
Нийт дүн		2,531.9	1,940.6	-591.3

Эх сурвалж: *Аудит хийсэн санхүүгийн тайлан*

Судалгаанаас харахад сумын ИТХ, ЗДТГ-ын төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь төсвийн зарлагын төлөвлөлттэй холбоотой байна. ОНХС, ХХС-гийн төсөв нь гүйцэтгэлтэй холбоотой бага гүйцэтгэлтэй гарчээ.

Ерөнхий боловсролын 3 дугаар сургууль 8.7 сая, Соёлын төв 9.5 сая төгрөгөөр тогтмол зардлын төсвийг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Цэнгэл сумын Засаг дарга нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 30.0 сая, засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 8.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5.2 сая төгрөгийн нийтдээ 43.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, хангамж, бараа материалын зардалд 2.7 сая, томилолтын зардалд 1.1, бараа үйлчилгээний бусад зардалд 39.2 сая төгрөгийг хамруулан зарцуулж, оны эцэст 0.2 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагсай сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 04-ны өдрийн 02/75 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 5,027.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 75.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 2 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын ОНХС-гийн 557.5 сая төгрөгийн, ХХС-гийн 99.0 сая төгрөгийн 73 орлогын, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 714.4 сая төгрөгийн зарлагын 125 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 50.0% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгдөөгүй байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар сумын Засаг дарга нарт “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж өгөгдсөн бөгөөд Цэнгэл нь малын татварын орлогыг сумын ИТХ-аар батлуулж ажиллаагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 218.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 217.7 сая төгрөгийн залруулга хийгдэж, 1.1 сая төгрөгийн акт тогтоосон байна.

Хүснэгт №4: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэнгэл сумын Засаг даргын тамгын газар	2	67.0	1	66.1	1	0.9				
2	Цэнгэл сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	0.6	-	-	1	0.6	-	-		
3	Цэнгэл сумын ОНХСан	-	-	-	-	-	-	-	-		
4	Цэнгэл сумын Хоршоо хөгжүүлэх сан	-	-	-	-	-	-	-	-		
Нийт дүн		3	67.6	1	66.1	2	1.5	-	-	-	-

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 29.1 сая төгрөгийн алдаа¹ илэрч 29.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залрууллаа. Залруулсан алдаа:

- Сумын 2023 оны орон нутгийн орлогын гүйцэтгэлийг цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхийн орлогыг 1.0 сая төгрөгөөр илүү, бусад нэр заагдаагүй орлогыг 12.7 сая төгрөгөөр илүү тайлагнаж ирүүлсэн.
- ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тохируулах бичилтийг алдаатай тайлагнаснаас нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг 16.4 сая төгрөгөөр дутуу тайлагнаж ирүүлснийг залруулав.

Аудитаар нийт 1,370.9 сая төгрөгийн зөрчил² илэрч албан шаардлага өгөгдсөн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шилэн данстай холбоотой 238.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, өгөгдлөө.

1. Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын ОНХС-гийн 557.5 сая төгрөгийн, ХХС-гийн 99.0 сая төгрөгийн 73 орлогын, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 714.4 сая төгрөгийн зарлагын 125 мөнгөн гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 50.0% байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган ирхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орон нутгийн орлогын гүйцэтгэлийн илүү тайлагнаж ирүүлсэн.	1	12,703.1			1	12703.1		12703.1				
Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	1	16,380.0			1	16,380.0	1	16,380.0				
Дүн	2	29,083.1			2	29,083.1	2	29,083.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Цэнгэл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цалингийн зардлаас бусад орлогын 73, зарлагын 125 ОНХС, ХХС-гийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй	2	1,370,875.1			2	1,370,875.1		
Дүн	2	1,370,875.1			2	1,370,875.1		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	2	1,370,875.1			2	1,370,875.1		